



ДОРНОД АЙМАГ  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН  
ДАРГЫН ТУШААЛ

2021 оны 12 сарын 28 өдөр

Дугаар А/39

Чойбалсан

Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн  
байдлыг хангах, хариуцлагатай жижүүр  
томилох тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5, Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4, 12.1.5, Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, Хөдөлмөрийн тухай хуулийн 52 дугаар зүйлийн 52.1, 76 дугаар зүйлийн 76.1.2, Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/36, А/611 дугаар тушаалыг үндэслэн ТУШААХ нь:

1. Нийтээр тэмдэглэх баярын өдөр шинэ жилийн 2021 оны 12 дугаар сарын 31-нээс 2022 оны 01 дүгээр сарын 02-ны амралтын өдрүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангах, хяналт тавих зорилгоор хариуцлагатай жижүүрийг томилон ажиллуулахыг Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Уламжлалт анагаах ухааны төв, сум, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн захирал, дарга нарт үүрэг болгосугай.

2. Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрийн хуваарийг нэгдүгээр, хариуцлагатай жижүүрийн ажиллах ажлын удирдамжийг хоёрдугаар, эрүүл мэндийн байгууллагаас мэдээ авах хүснэгтийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдлыг хангаж, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгч ажиллахыг Захиргаа, удирдлага, эдийн засаг, мэдээллийн хэлтэс /Я.Эрдэнэтуяа/, Эмнэлгийн тусламжийн хэлтэс /Ч.Оюунтунгалаг/, Нийгмийн эрүүл мэндийн төв /Б.Сарнай/ -д тус тус үүрэг болгосугай.

4. Эмнэлгийн тусламж үйлчилгээний мэдээ тайланг үнэн зөв бүртгэж, шаардлагатай тохиолдолд холбогдох удирдлагуудад мэдээлж ажиллахыг хариуцлагатай жижүүр, мэргэжилтнүүдэд үүрэг болгосугай.


5. Хариуцлагатай жижүүрээр ажилласан мэргэжилтнүүдийг холбогдох хууль тогтоомж, журамд заасны дагуу нөхөн амруулж, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хүний нөөцийн менежер /Я.Эрдэнэтуяа/-т даалгасугай.

ДАРГА

Ч.ОЮУНАА

9031774 0719110006

Эрүүл мэндийн газрын даргын .....оны  
.92. дугаар сарын 28...ны/ний өдрийн  
1/39...дугаар/дүгээр тушаалын  
нэгдүгээр хавсралт




### ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН ХУВААРЬ

Ажил-лах өдөр	Ажил-лах цаг	Хариуцлагатай жижүүр хийх мэргэжилтэн	Албан тушаал	Утас	Хяналт тавих албан тушаалтан
2021 оны 12 дугаар сарын 31-ний Баасан гараг					
1	24 цаг	М.Баяртунгалаг	Орчны асуудал хариуцсан мэргэжилтэн	86730706	Б.Сарнай 94009639
2022 оны 01 дүгээр сарын 01-ний Бямба гараг					
2	24 цаг	Г.Ариунзаяа	Эрүүл мэндийн статистик, мэдээллийн хариуцсан мэргэжилтэн	88104585	Я.Эрдэнэтуяа 94006177
2022 оны 01 дүгээр сарын 02-ний Ням гараг					
3	24 цаг	А.Батболд	Мэдээлэл, технологийн асуудал хариуцсан мэргэжилтэн	99854448	Я.Эрдэнэтуяа 94006177

ooOoo



Эрүүл мэндийн газрын даргын .....оны  
12 дугаар сарын 28 ны/ний өдрийн  
139 дугаар/дүгээр тушаалын  
хоёрдугаар хавсралт



## ХАРИУЦЛАГАТАЙ ЖИЖҮҮРИЙН АЖИЛЛАХ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг зүйл.

1.Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эмнэлгийн тусламж үйлчилгээний тасралтгүй, бэлэн байдлыг хангах, эрсдлээс сэргийлэх, хяналт тавихтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.

2.Бүх шатны эрүүл мэндийн байгууллага энэхүү нийтлэг журмыг үндэслэн, байгууллагын өвөрмөц нөхцөл байдалтай уялдуулан тусламж үйлчилгээний бэлэн байдалд хяналт тавих хариуцлагатай жижүүрийг томилгоожуулан, үйл ажиллагааны удирдамжийг батална.

3.Удирдамжид бүх төрлийн эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц бүрдүүлэлт, учирч болзошгүй эрсдлийг тооцох, сэргийлэх, үйлчилгээнд хяналт тавьж ажиллах чиглэлээр хариуцлагатай жижүүрийн үүрэг, хариуцлагыг тусгана.

4.Удирдамжид тухайн байгууллагын болон харьяа байгууллагынхаа тоног төхөөрөмж, түргэн тусламжийн автомашины бэлэн байдалд хяналт тавьж ажиллах, аргачлал, үйл ажиллагааг тусгана.

5.Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн салбарт гаргаж, мэдээлэх үзүүлэлтийг Эрүүл мэндийн сайдын “Эрүүл мэндийн салбарын статистик мэдээ, мэдээллийн журам, бүртгэлийн маягт”-д заасан маягтын дагуу холбогдох эрүүл мэндийн байгууллагууд гаргаж мэдээллэнэ.

Хоёр. Удирдлага зохион байгуулалт.

1.Эрүүл мэндийн газарт тухайн орон нутгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд нийгмийн эрүүл мэндийн үйл явдал, эрүүл мэндийн байгууллагын үйл ажиллагаанд хяналт тавьж, зохицуулж ажиллах жишиг чиг үүрэг бүхий хариуцлагатай жижүүрийг томилно.

2.Эрүүл мэндийн байгууллагууд байгууллагын дотоод, гадаад үйл ажиллагаа, тухайн эрүүл мэндийн байгууллагын тусламж үйлчилгээний бэлэн байдал болон харьяаллын хүн амын эрүүл мэндэд хяналт тавих жишиг чиг үүрэг бүхий хариуцлагатай жижүүрийг томилно.

3.Хариуцлагатай жижүүрүүдийн үйл ажиллагаа нь 24 цагийн тасралтгүй байдлыг хангасан байх бөгөөд энэхүү тушаалаар баталсан нийтлэг удирдамжийн хүрээнд үйл ажиллагааг нарийн зохицуулсан байна.

4.Ерөнхий жижүүрээс бусад хариуцлагатай жижүүр нь энэхүү тушаалын гуравдугаар хавсралтад заасан “Бүх нийтээр тэмдэглэх баяр, тэмдэглэлт өдрийн амралтын үед эрүүл мэндийн салбарт гаргаж, мэдээлэх үзүүлэлт”-ийг үнэн зөв гаргаж, баталгаажуулан холбогдох шатанд ирүүлж байх нийтлэг үүрэгтэй.

Гурав. Мэдээний урсгал.

1.Бүсийн оношилгоо эмчилгээний төв, Уламжлалт анагаах ухааны төв, өрх, сумын эрүүл мэндийн байгууллагат ажиллаж буй хариуцлагатай жижүүр нь Эрүүл мэндийн сайдын 2020 оны А/611 дүгээр тушаалын арваннэгдүгээр хавсралт хүснэгтийн дагуу гаргаж тус өдрийн мэдээг дараагийн өдрийн өглөөний 08:00 цагт Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрт мэдээлнэ.



2.Эрүүл мэндийн газарт ажиллаж буй хариуцлагатай жижүүр нь харьяа байгууллагаас мэдээ авч, нэгдсэн дүнг Эрүүл мэндийн хөгжлийн төв (ЭМХТ)-ийн хариуцлагатай жижүүрт ирүүлнэ.

3.Эрүүл мэндийн хөгжлийн төв нь байгууллагаас мэдээг бүрэн гаргуулан авч салбарын нэгдсэн дүн мэдээг гаргаж Эрүүл мэндийн яаманд мэдээлнэ.

4.Эрүүл мэндийн яамны 24 цагийн турш мэдээ хүлээж авах утасны дугаар: 11-323002, ЭМХТ-ийн хариуцлагатай жижүүрийн утас: 70128801, Эрүүл мэндийн газрын хариуцлагатай жижүүрийн утас: 70583366

Дөрөв. Эрүүл мэндийн байгууллагын хариуцлагатай жижүүрийн нийтлэг чиг үүрэг.

1. Эрүүл мэндийн байгууллага хариуцлагатай жижүүрийн нэрс, утасны дугаар, тогтмол нээлттэй байх цахим хаягийг, ЭМЯ, ЭМХТ-д урьдчилан ирүүлсэн байна.

2. Энэхүү тушаалын гуравдугаар хавсралтаар баталсан мэдээг тухайн жижүүрийн хугацаанд өмнөх өдрийн мэдээ дээр нэмэгдсэн байдлаар гарган ЭМХТ-ийн жижүүрт ирүүлж, шаардлагатай тохиолдолд утсаар тодруулга өгч ажиллана.

3. Хариуцлагатай жижүүр нь тухайн өдрийн хуваарьт цагтаа ирж, жижүүрийн хавтас дахь материал, өмнөх жижүүрийн нэгдсэн мэдээ, тайлантай танилцана.

4. Жижүүр хүлээж авсан тухайгаа тухайн өдөр хяналт тавьж ажиллах удирдах ажилтанд мэдэгдэнэ.

5. Эрүүл мэндийн байгууллагын хариуцлагатай жижүүр нь ирүүлж байгаа мэдээний үнэн зөвийг хариуцаж ажиллах ба тухайн ирүүлж буй мэдээг байгууллагын удирдлагаас тухайн хяналт тавьж ажиллаж байгаа албан тушаалтанд хянуулж, баталгаажуулж ирүүлнэ.

6. Нийтийг хамарсан ноцтой байдал үүссэн үед шалтгаан, нөхцөл байдал, үүсч болзошгүй эрсдлийг тооцож холбогдох арга хэмжээг шуурхай зохион байгуулна.

7. Гамшиг осол, НЭМ-ийн ноцтой байдал үүссэн тухай бүрт шаардлагатай нэмэлт мэдээлэл, үйл ажиллагааны явцын мэдээ, тайланг холбогдох байгууллагаар гаргуулан бүх шатны удирдлагыг мэдээллээр хангаж ажиллана.

8. Шаардлагатай үед мэдээллийг Эрүүл мэндийн яам, Онцгой байдлын ерөнхий газар, Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын шуурхай удирдлагын төв /хэлтэс/-д шууд мэдээлж, тайланд тусгаж ажиллана.

Тав.Эрүүл мэндийн байгууллагын үүрэг

1.Бүх нийтийн амралтын өдрүүдэд эмнэлгийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, байгууллагын техник, тоног төхөөрөмжийн бэлэн байдал, хийн хангамж, эмнэлгийн яаралтай тусламжийн бэлэн байдал, түргэн тусламжийн машин, эм эмнэлгийн бэлэн байдлыг хангах төлөвлөлт, зохицуулалтыг хийж ажиллана.

2.Бүх нийтийн амралтын үед эх, хүүхдийн эрүүл мэнд, нас баралт, нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдал, хордлого, халдварт өвчин, гэнэтийн осол, гэмтэл, яаралтай, түргэн тусламж, цаг агаарын аюулт үзэгдэл, олныг хамарсан өвчлөл, эндэгдэлд хяналт тавьж ажиллана.

3.Байгууллагын хариуцлагатай жижүүрийн үүрэгт дээрх асуудлуудад хяналт тавих чиг үүргийг тодорхой тусгаж өгнө.

4.Бүх нийтийн баяр, тэмдэглэлт өдрөөс 14 хоногийн өмнө тухайн өдрүүдэд ажиллах хариуцлагатай жижүүр хийх албан тушаалтныг томилж, холбогдох байгууллагуудад хүргүүлнэ.

5.Хариуцлагатай жижүүрт зориулж холбогдох журам, заавар, байгууллагын эмч, эмнэлгийн мэргэжилтэн, эрүүл мэндийн ажилтнуудын болон бусад байгууллагын утас, цахим хаяг, бусад мэдээ, мэдээллийг багтаасан жижүүрийн хавтсыг бэлтгэнэ.

6.Хариуцлагатай жижүүрээр ажиллах мэргэжилтэн болон бүх албан тушаалтнуудад урьдчилсан мэдээллийг өгч, чиг үүргийг танилцуулж, гарын үсэг зуруулж батагаажуулна.

7.Хариуцлагатай жижүүр ажиллах өрөөнд интернэт холболт бүхий компьютер, хэвлэгч, 24 цаг нээлттэй байх утас байршуулна.

Зургаа. Хориглох зүйлс.

1. Хариуцлагатай жижүүр нь цагаас хоцрох буюу тухайн өдөртөө жижүүрийн үүргийг тасалдуулах,

2. Мэдээ дутуу авах болон дутуу өгөх,

3. Тухайн жижүүрийн хугацааны мэдээг албажуулан нэгтгэл хийхгүй буух,

4. Хариуцлагатай жижүүрийн үүрэг, үйл ажиллагаанд тусгасан асуудлыг шалтгаангүй зөрчих зэрэг болно.

ooOoo



Эрүүл мэндийн газрын даргын ..... оны  
 .12.. дугаар сарын 28...ны/ний өдрийн  
 1/39 дугаар/дүгээр тушаалын  
 гуравдугаар хавсралт

9031774 0719110006

БУХ НИЙТЭЭР ТЭМДЭГЛЭХ БАЯР, ТЭМДЭГЛЭЛТ ӨДРИЙН АМРАЛТЫН ҮЕИЙН ЭМНЭЛГИЙН ТУСЛАМЖ  
 ҮЙЛЧИЛГЭЭГ МЭДЭЭЛЛЭХ БҮРТГЭЛ

№	Үзүүлэлт	Мөр	БОЭТ	УАУТ	Өрх, сумын эрүүл мэндийн төв	Нийт дүн
А	Б	В	1	2	3	5
1	Төрсөн эхийн тоо	1				
2	Амьд төрсөн нярай	2				
3	Амьгүй төрсөн хүүхэд	3				
4	Нас барсан хүний тоо	4				
5	Үүнээс: эмнэлэгт	5				
6	Хоног болоогүй нас баралт	6				
7	1 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	7				
8	1-5 хүртэлх насны хүүхдийн эндэгдэл	8				
9	Осол гэмтлийн улмаас нас барсан хүний тоо	9				
	Зам тээврийн ослоор	10				
	Хөлдөлт, осголт	11				
	Архины шалтгаант	12				
	Хордлогоор	13				
	Хоолны	14				
	Бусад	15				
	Бусад ослоор	16				
10	Үүнээс	17				
11	Амбулаторийн нийт үзлэг	18				
12	Үүнээс: Томуу, томуу тест өвчний учир	19				
13	Томуу, амьсгалын замын өвчний амбулаторийн үзлэгт эзлэх хувь	20				
	Нийт					
14	Хүлээн авах, яаралтай					
	Насанд хүрэгчид					
	Үүнээс: Хөдөө орон нутгаас					

тусламжийн тасгаар үйлчлүүлсэн иргэдийн тоо	Осол гэмтлийн шалтгаант	Яаралтай мэс засал	21			
		Зурх судас, мэдрэл эмгэг	22			
Хүүхэд	Хэвтсэн	Хордлого	23			
		Архи	24			
	Хоол	25				
	Авто осол	26				
	Түлэгдэлт	27				
	бусад гэмтэл	28				
	Дотрын өвчний шалтгаант	29				
	Бусад шалтгаант	30				
	Буцаасан	31				
	Насанд хүрэгчдийн нас баралт	32				
Хүүхэд	Хэвтсэн	Нийт	33			
		Хөдөө орон нутгаас	34			
	Осол гэмтлийн шалтгаант	35				
	Яаралтай мэс засал	36				
	Томуу, томуу төст өвчин, амьсгалын замын өвчлөл	37				
	Хордлого	38				
	Авто осол	39				
	Түлэгдэлт	40				
	бусад	41				
	Бусад	42				
Эрчимт эмчилгээний тасагт байгаа хүний тоо	Хүүхдийн нас баралт (0-5)	Буцаасан	43			
		Нийт	44			
хүүхэд	Уушгины хатгалгаа	Нас баралт	45			
		Эмчлүүлж байгаа тоо	46			
	Бусад	47				
			48			

		насанд хүрэгчид	Нийт	Эмчлүүлж байгаа тоо	49			
			Уушгины хатгалгаа	Нас баралт	50			
			Бусад		51			
			Нийт		52			
		Хүүхэд	0-5 насны хүүхдийн томуу, амьсгалын замын өвчлөл		53			
			Хордлого		54			
			Халдварт өвчин		55			
			Бусад		56			
			Нийт		57			
			Осол гэмтэл	Архи	58			
				Хоол	59			
				Бусад	60			
		Насанд хүрэгчид	Төрөх		61			
			Халдварт өвчин		62			
			Бусад		63			
		Түргэн тусламжийн дуудлагад тохиолдсон нас баралт			64			
					65			
		Орон нутагт гарсан олныг хамарсан аюулд өртсөн хүний тоо/4 ба түүнээс дээш хүн/			66			
					67			
					68			
					69			
					70			
16	Түргэн тусламжийн дуудлагын тоо				71			
					72			
					73			
					74			
					75			
					76			
					77			
17	Орон нутагт гарсан олныг хамарсан аюулд өртсөн хүний тоо/4 ба түүнээс дээш хүн/							
18	Зоонозын өвчний сэжигтэй тохиолдол							
19	Сэжигтэй							
20	Коронавирусын							
21	халдварын							
22	тохиолдол							
23	Коронавирусын							
24	халдварт							



25	зориулсан орны тоо	Ашиглаж орны тоо	Энгийн	78			
26	Коронавирусын халдварын сэргийлэлт, хяналт, оношилгоо, эмчилгээнд ажиллаж буй эмч, мэргэжилтний тоо	Нийт Их эмч Сувилагч Тархвар судлаач	Эрчимт эмчилгээ	79			
27				80			
28				81			
29				82			
30				83			
31		Бусад		84			
32	Амьсгалын аппаратын тоо			85			
33	Хүүхдийн орны тоо			86			
34	Хүүхдийн сул орны тоо			87			
35	Хэвтэн эмчлүүлж буй хүний тоо	Нийт		88			
36	Мэс засал хийлгэсэн үйлчлүүлэгчийн тоо	Үүнээс: хөдөө орон нутгаас		89			
37		Нийт		90			
38		Төлөвлөгөөт мэс засал		91			
39		Яаралтай мэс засал		92			

ooOoo